



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

“Чингэлтэй дүүргийн нийтлэг
үйлчилгээний газар” орон нутгийн өмчит
төсөвт үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай” 56 дугаар тогтоолын хавсралтын хоёрдугаар зүйлийн “2.1.2. Дүүрэг, дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодын байрны харуул хамгаалалт, камержуулалт, камер арчлалтын үйлчилгээ үзүүлэх” гэснийг “2.1.2. Дүүрэг, дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодын байрны дохиолол, харуул хамгаалалтыг хариуцаж ажиллах” гэж, “2.1.4. Дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодын байрны цахилгаан сантехник, цэвэр, бохир ус, дулаан дамжуулах инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ үзүүлэх”; гэснийг “2.1.4. Дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодын байрны цахилгаан сантехник, цэвэр, бохир ус, дулаан дамжуулах инженерийн шугам сүлжээ, худгийн засвар үйлчилгээ үзүүлэх” гэж; “2.1.5. Автобааз, авто зогсоолын үйлчилгээ үзүүлэх” гэснийг “2.1.5. Автотээвэр болон авто зогсоолын үйлчилгээ үзүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай” 56 дугаар тогтоолын хавсралтын хоёрдугаар зүйлд “2.1.3. Дүүрэг, хороодын байрны дотоод сүлжээ, интернэтийн засвар, үйлчилгээ үзүүлэх;” “2.1.7. Дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодод тусгай зориулалтын авто машинаар бохир ус зөөвөрлөх, татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх” гэснийг тус тус хассугай.

3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай” 56 дугаар тогтоолын хавсралтын хоёрдугаар зүйлд “2.1.6. Дүүргийн нутаг дэвсгэрт орчин үеийн

шийдэл бүхий сэргээгдэх эрчим хүчний засвар, угсралтын үйлчилгээ үзүүлэх”;
“2.1.7.Дүүргийн өмчид бүртгэлтэй нийтийн ариун цэврийн байгууламж, халуун усны
байр, автобусны буудлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг үзүүлэх” гэж тус тус
нэмсүгэй.

4.Энэ дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хууль, тогтоомжид заасны дагуу хуулийн
этгээдийн Улсын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг
дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг
дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР